| Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар | | | | | | | |
| 2024 оны эхний хагас жил | | | | | | | |
| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилт хувь |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 1 | 3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ. | 3. Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ | 2021 - 2024 | 1.0 тэрбум - ЖДҮХСан | Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 50-аас доошгүй ААН-д хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын дэмжлэг үзүүлнэ | ХХААХҮ-ийн сайдын А/28 дугаар тушаалаар батлагдсан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн зориулалтаар аймагт 1,0 тэрбум төгрөг хуваарилагдан тус төсөлд 27 ААН-ийн төсөл тэнцэн дараагын шатанд шилжсэн. ЖДҮГазрын даргын А/73 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэгт Зээл төслийн хэлтсийн мэргэжилтэн Б.Ган-Очир, Хууль тусгай активын хэлтсийн мэргэжилтэн Э.Энхтуяа нар 5 сарын 6-10-ны өдөр хүртэл газар дээрх судалгаа буюу нарийвчилсан судалгааг хийсэн. Нарийвчилсан судалгаанд 1,8 тэр. бум төгрөгийн санхүүжилт хүссэн 12 ААНэгжийн төсөл тэнцээд байна. Дэд хорооны хурал 6 сарын 5-ны өдөр хуралдаж тэргүүн ээлжин санхүүжих 1.0 тэрбум төгрөгийн 8 төсөл, хоёрдугаар ээлжинд санхүүжих 570.0 сая | 70 |
| 2 | 3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. | 2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | УТ-50.0 сая | Ээрэх, нэхэх, сүлжих хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлснээр 100 орчим ажлын байр бий болсон байна. Ээрэх үйлдвэрийн хүчин чадлыг 300 тонноор нэмэгдүүлнэ. | Их онь ХХК 163 тн ноосыг угаасан. Одоогын байдлаар 30 ажилтан ажиллаж байна. ЖДҮХСанд Тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр Эрдэнэдалай сумын Ембүү хонгор ХХК 50,0 сая.төгрөгийн санхүүжилт хүссэн төсөл ирсэн нь Аймгийн дэд хорооны хурлаар дэмжигдсэн. Одоо зээл авах материалаа бүрдүүлж байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй суурины тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно. | 5. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна. | 2020 - 2024 | ОНТ-400.0 | 18 сум | 2024 оны аймгийн төсөвт Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын үлдэгдэл санхүүжилт 28.4 сая сая төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэгч Ланд Овнер ХХК-ийн ажлын удаашралаас хамаарч хойшлогдоод байна. Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авснаар Дундговь аймгийн 15 сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон. | 70 |
| 4 | 3.7.9. Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ. | 8. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна. | 2020 - 2024 | | Түрээсийн орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. | Хаус хорооллын ерөнхий төлөвлөгөөг хүлээн авснаар тус хорооллыг дагасан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж эхлээд байна. Хаус хороолол төлөвлөсөн нийт 8 га талбайд цэвэр бохир, ус, халаалтад холбогдсон, хашаа, гарааштай орчин үеийн шийдэл бүхий 119 амины орон сууц байх юм. 2024 оны аймгийн ОНХС болон ОНХО-аар тус хорооллын гадна бохир усны шугамын ажилд 208.9 сая, гадна цахилгаан хангамж, дэд станц байгуулах ажилд 89.0 сая нийт 297.9 сая төгрөг батлагдаж гүйцэтгэгч шалгаруулах шатандаа явж байна. Сайнцагаан сумын айраг баг, Адаацаг сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн 0.4кВ-ын ЦДАШ, дэд станц шинээр барих ажилд нийт 498.6 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталснаар ойролцоогоор 1000 гаруй өрхүүд өмчилж авсан газартаа амьдрах орчин бүрдэж байна. Аймгийн 2024 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 4. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | Барилгын ажлыг үргэлжлүүлнэ. | ЭЗХЯ-ны зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний зардалд Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтын ажлын зураг, төсөв шинэчлэх зөвлөх үйлчилгээнд 50.0 сая төгрөг батлагдан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн шатандаа явж байна. | 30 |
| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | |
| 6 | 4.3.11. Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлэх, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг | 2. Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна. | 2021 - 2024 | | Өмнөговийн Даланзадгад, Дорноговийн Хөвсгөл, Сүхбаатарын Онгон, Дорнодын Матад, Хэнтийн Биндэр суманд нийт 5 цогцолбор байгуулна. Хэнтийн Баянхутаг, Сүхбаатарын Түмэнцогт, Дундговийн Сайнцагаан суманд нийт 3 цогцолбор байгуулна. | Дундговь аймгийн Эрдэнэдалай, Сайнцагаан, Говь-Угтаал сумдад аюулаас амжиж анхааруулах цогцолбор 107,5 радио ажиллаж, аймгийн хэмжээнд 15 толгойн сэргийлэгч малчин, цаг агаарын мэдээллийг багц мессежээр хүргэх 17 төхөөрөмж ажиллаж малчид иргэдэд цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ зөвлөмжийг цаг алдалгүй хүргэсэн. Хагас жилийн байдлаар сэрэмжлүүлэг мэдээллийг радиогоор 10 удаа, багц мессежээр 17 удаа 9980 хүнд хүргэж ажилласан. Хагас жилийн байдлаар эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага бүртгэгдээгүй. | 100 |
| 7 | 4.6.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ. | 1. Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион | 2020 - 2024 | | Сум, дүүргийн орон нутгийн хамгаалалтын 340 төлөвлөгөөг хянаж, тодотгол хийгдэнэ. | Дайчилгааны тухай хууль 18.1.1, 1.2-д заасны дагуу 2023 оны 01 дүгээр сард цэргийн бүртгэлийн үеэр Цэргийн штабын дарга болон орон нутгийн бэлтгэл, сургалтын офицер нар сумдын орон нутгийн хамгаалалтын отрядын бүрэлдэхүүний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | | 2. Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог бүрдүүлэх, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангана. | 2020 - 2024 | | Орон нутгийн цэрэг, томилгоот нэгжийн 22 сургалт зохион байгуулагдана. | 2024 онд Цэргийн штабын “Сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага, сургалтыг Эрдэнэдалай сумд 80 хүнтэйгээр 9 дүгээр сард хээрийн дадлагаар зохион байгуулахаар төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулж, | ХБ |
| 9 | | 3. Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврыг | 2020 - 2024 | | Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөний боловсруулалт бүрэн хийгдэнэ. | МУ-ын Засгийн газрын 2023 оны мн/494 "Аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар батлах тухай" тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2024 оны “Зөвлөмж, заавар хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу “Дундговь аймгийн улсын дайчилгааны төлөвлөгөө”-г боловсруулах аргачлал зааврын дагуу дайчилгааны офицер, улсын | 50 |
| ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 10 | 5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | 1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ. | 2020 - 2024 | ОНТ 3.0 Хувийн хэвшил 9.0 | Улаанбаатар хот болон төв суурин газрын 2000-аас доошгүй жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Монголын жорлонгийн ууган холбоо ГҮТББ-тай хамтран байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Эко жорлон” арга хэмжээ зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 15 сумын удирдлагууд, төрийн албан хаагч, иргэд 120 хүнд Нүхэн жорлонг стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага, Нүхэн жорлонгийн стандарт, Эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүдийн талаар сургалт зохион байгуулсан. Мөн “Эко жорлон” үзэсгэлэнгээр хуурай технологийн 8 төрөл, электрон ухаалаг нэг, ус хэмнэлтийн хуйлруулагч хошуу бүхий 2 төрөл, соруулдаг нүхэн жорлонгийн 1 төрөл нийт 13 төрлийн жорлонгийн танилцуулга, үзэсгэлэнг 200 гаруй иргэд үзэж сонирхсон байна. 2024 онд шинээр стандартын шаардлага хангасан 5 ариун цэврийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ. | 1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ. | 2020 - 2024 | Хувийн хэвшлийн 2.0 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. | Аймгийн 3 сумын нутаг дэвсгэрийн 5 байршилд уул уурхайн ашиглалт, хайгуулын үйл ажиллагаа явуулдаг 5 аж ахуйн нэгж ашиглалт, олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 4.87 га, хайгуулын үйл ажиллаганаас эвдэрсэн 0.09 га, эзэнгүй эвдэрч орхигдсон 4.9 га, нийт 9.86 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. | 100 |
| 12 | 5.1.11. "Хөх морь" төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ. | 2. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна. | 2020 - 2024 | | Хөв цөөрмийг 3-аас доошгүй газарт шинээр байгуулах, 120-аас доошгүй булаг шандны эхийг хашиж хамгаалсан байна. | Гурвансайхан сумын Их газрын чулууны ууланд Баян-Уул, Ерлөгийн ууланд 2 цэгт зэрлэг амьтан ундаалах хөв цөөрөм байгуулахаар ажлын даалгавар боловсруулан тендер зарлаад байна. “Дундговь” ХХК-тай гэрээ байгуулж Өлзийт сумын “Сүүжийн булаг”, “Баруун билүүний булаг”, Сайхан-Овоо сумын “Өвөр булаг” нийт 3 булгийн эхийг хашиж хамгаалах ажлын гэрээ байгуулав. | 30 |
| ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 13 | 6.2.5. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ. | 1. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ. | 2021 - 2024 | | Хэрэгжилтийг хангана. | Дундговь аймагт Арина электроникс, Сайн электроникс ХХК-ууд салбараа нээж үйл ажиллагаагаа эхэлсэн. УБ хотоос шилжин ирсэн “Дэлгэрэх плас инженеринг” ХХК ахуй үйлчилгээний төв нээхээр ЖДҮХС-н зээлд хамрагдахаар төслөө өгч шалгаруулалтын шатандаа явж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 6.2.8. Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 1. Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрт гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцлийг сайжруулна. | 2020 - 2024 | | Гэр хорооллын 3500 өрх инженерийн сүлжээнд холбогдсон байна. | 2024 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн төвийн гэр хорооллын 15 айл өрх ус хангамжийн техникийн нөхцөл авч цэвэр усанд холбогдсон. Мөн орон нутгийн 650 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан сумын 7 дугаар баг Мандал хорооллын гадна халаалтын зуухны ажил хийгдэж байгаа бөгөөд тус ажил ашиглалтад орсноор нийтийн болон хувийн орон сууц, аж ахуйн нэгжүүд халаалтад холбогдох нөхцөл бүрдэнэ. Тус ажлыг 2024 оны 7 дугаар сард ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>Өмнөх онд Хаус хорооллын ерөнхий төлөвлөгөөг хүлээн авснаар тус хорооллыг дагасан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж эхлээд байна. Хаус хороолол төлөвлөсөн нийт 8 га талбайд цэвэр бохир, ус, халаалтад холбогдсон, хашаа, гарааштай орчин үеийн шийдэл бүхий 119  амины орон сууц байх юм. 2024 оны  аймгийн ОНХС болон ОНХО-оор тус | 100 |
| 15 | 6.2.10. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна. | 1. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна. | 2021 - 2024 | ОНТ 42.0 | | Сайнцагаан, Адаацаг, Говь-угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайхан-овоо, Эрдэнэдалай сумдад дахивар авах цэг ажиллаж байгаа бөгөөд 2024 оны эхний хагас жилийн байдлаар 68 тонн дахивар нөөц цуглуулан дахин боловсруулах үйлдвэр болон үйлдвэрлэгч ААН-д тушаасан.Луус суманд хуванцар пресслэгч машинтай болж иргэнд ашиглуулахаар гэрээ байгуулсан.<br>Дэлгэрхангай сумын дахивар цуглуулж буй иргэнд байгаль хамгаалах сангаас 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Аймгийн төвийн орон сууцны хорооллуудад 9ширхэг ангилан ялгах хогийн сав буюу дахивар цуглуулах цэг байршуулсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 6.2.12. Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ. | 1. Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна. | 2021 - 2024 | | Албаны орон сууцаар хангагдсан байна. | Эрүүл мэндийн салбарын нийт албан хаагчдын 43,3 хувь гэр болон түрээсийн байранд амьдарч байна. Өндөршил сумын Эрүүл мэндийн төвд шинээр ирсэн 1 эмчийг албаны байранд оруулж, тогтвортой ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Алслагдсан 14 сумын 268 багшийн 82,4 хувь гэр болон амины орон сууцанд, 39 багш буюу 15,1 хувь төрийн албан хаагчийн байранд, 3 багш дотуур байранд нийт 43 багшийг орон байраар ханган дэмжлэг үзүүлээд байна. Онцгой байдлын газар албаны тус бүр 2 өрөө орон сууцанд 5 алба хаагчийг гэр бүлийн хамт үнэ төлбөргүйгээр суулгаж нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. | 100 |
| 17 | 6.2.13. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 2021 - 2024 | | Ажлын байр нэмэгдсэн байна. | Мах, махан бүтээгдэхүүн болон арьс шир боловсруулах чиглэлээр энэ онд 6 аж ахуйн нэгж нийт 1,0 тэрбум төгрөгийн хүсэлт ирүүлсэн байна. Эдгээр төслүүд эхний шатандаа тэнцэн ЖДҮГазраас нарийвчилсан судалгаа хийгдэж 420,0 сая.төгрөгийн 3 төсөл тэнцсэн. 6 сарын 5-ны өдөр болсон дэд хорооны хурлаар 2 төсөл 270.0 сая.төгрөгийн санхүүжилт авахаар болсон. Уг төслүүд | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | 6.2.14.. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно. | 2. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно. | 2021 - 2024 | ХХ-431.81 | Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ. | Жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийг ажлын байртай болгосноор үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлсэн. Бизнес хөгжлийн төвд 5 аж ахуй нэгж, 7 бизнес эрхлэгч үйл ажиллагаа явуулж 2024 он гарсаар 341.31 сая.төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан.<br>Бизнес эрхлэгч нарын борлуулалтыг дэмжих зорилгоор Дундговьд үйлдвэрлэв дэлгүүрийг ажиллуулж байна. Тус дэлгүүрээр 13 ААНэгж, 141 иргэний нийт 122 нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. 2024 он гарсаар 90.5 сая.төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан.<br>“Олон улсын Жижиг, дунд үйлдвэрийн өдөр 2024” “Олон улсын хоршооллын өдөр”-ийн хүрээнд Улаанбаатар хотод 6 сарын 12-16нд  зохион байгуулж буй үзэсгэлэн худалдаанд Хан дээж ХХК, | 100 |